

Монгол хэлний “аргал” хэмээх цогц ойлголтод хийсэн ажиглалт

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Дашдамбын ЭРДЭНЭСАН*

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм,
Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн
Монгол хэлний тэнхим*

WUYUNQIQIGE**

*БНХАУ. Өвөр Монголын Алишаа зүүн хошууны монгол үндэстний сургууль***Received:** May 15, 2024**Revised:** October 29, 2024**Accepted:** November 04, 2024

Хураангуй: Тус өгүүлэлд “Аргал” хэмээх цогц ойлголтыг соёл, хэл шинжлэлийн үндсэн ойлгогдохууны нэг болох орон зайн утга илтгэх талаас ажиглав. Үг хэл нь цаг хугацааны соёлыг илэрхийлээд зогсохгүй орон зайн утгаас ангид зүйл биш юм. Газар зүйн орчин тойрон нь үг хэлний онцлог буй болоход чухал нөлөө үзүүлдэг. Соёлын үзэгдэл болохын хувьд хэл нь орон зайнаас ангид зүйл биш юм. Учир нь хэлний үйл ажиллагаа эрхэлдэг субъект нь газар зүйн тодорхой орон зайн бүтцэд ямагт оршдог бөгөөд энэхүү орон зайн соёл нь хэлээр харилцагч ард түмний бодол санаа, ухамсар гэх мэтэд нөлөөлдөг байна. Тиймээс энэхүү орон зайн соёлын талаарх ойлголт нь тухайн хэлэнд өвөрмөц үгсийн сангийн систем, хэл зүйн дүрэм, дуудлагын хэв ёс, уран сайхнаар дүрслэх арга ухааныг бий болгодог. Улмаар газар зүй, орон зайн хүрээнд хэл, соёлын тогтолцоо бий болдог тухай энэ өгүүлэлд авч үзнэ.

Түлхүүр үг: Аргал, цогц ойлголт, газар зүй, орон зай, зүйр цэцэн үг, хэл соёл

* © Д.Эрдэнэсан, 2024

✉ corresponding author Email: erdenesan@msue.edu.mn

** © WUYUNQIQIGE, 2024

Email: 3639389320@qq.com

An Analytical Study on the Comprehensive Concept of Argal in the Mongolian Language

ERDENESAN Dashdamba

Department of Mongolian language, School of Humanities, Mongolian National University of
Education, Ulaanbaatar, Mongolia

WUYUNQIQIGE

Mongolian ethnic school in Alshaa Eastern Province, Inner Mongolia, China

Abstract: This article explores the concept of *argal*, one of the main concepts in Mongolian culture and linguistics, from the perspective of spatial meaning. In addition to reflecting the culture of a particular time, words and phrases are also connected to spatial meaning. The geographical environment plays a significant role in shaping the development of word and phrase characteristics. As a cultural phenomenon, language is influenced by spatial factors. This is because language users are always situated within a specific geographic space, and the culture of that space affects their thoughts, consciousness, and so on. Consequently, the cultural understanding of a space shapes the vocabulary system, grammatical rules, phonetic patterns, and artistic representational techniques that are unique to that language. Furthermore, this article examines the formation of language and cultural systems within these spatial contexts.

Keywords: *dung (argal), concepts, geography, space, proverbs, language and culture*

1. Удиртгал

Монголчууд таван хошуу малыг гаршуулж, гэршүүлж авсан нь гэнэтийн тохиолдол биш. Бидний оршин амьдарч буй байгаль орчинтой холбоотой зүйл гэж үздэг. Монголын газар нутгийн бүсчлэлийг ойт хээр, тал хээр, говь цөл гэх мэтээр ялгадаг бөгөөд тал хээр, өндөрлөг бүс, булаг шанд, гол ус, сайрын бэлчээр гэх мэт байгалийн тогтцоос шалтгаалан монголчууд, таван хошуу малынхаа аль илүү тохиромжтойг голлож адгуулан хариулж ирсэн онцлогтой юм. Монголчууд ийнхүү оршин амьдарч байгаа газар зүйн орчин тойрныхоо онцлогоос шалтгаалж өөртөө тохирсон аж ахуйн хэлбэр бэлчээрийн мал аж ахуй эрхлэх явцдаа өөр өөрийн онцлог бүхий нүүдлийн соёл иргэншлийг бүтээж бий болгожээ. Аливаа үндэстний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл, танин мэдэхүйн туршлага, соёл, ёс заншил, бэлгэдэх ёс, эрхэлж буй аж ахуй зэрэг нь тухайн үндэстнийхээ үг хэлнээ тусгалаа олсон байдгийг судлаачид олон талаас баталсан байдаг. Үүнчлэн өөр өөр түүх, өөр өөр нийгэм, өөр өөр орон зай үг хэлний өөр өөр хэв маягийг бүрдүүлдэг нь мэдээж. Энэхүү олон ялгааг тухайн үндэстний үг хэлний баримтаас эрж хайж, таньж мэдэж болох юм. Бид энэ удаад хэл соёлын ойлгогдохууны нэг “Аргал” хэмээх цогц ойлголт монголчуудын онцгой хэв маяг бүхий орон зайн соёлыг илэрхийлж байгааг жишээ баримтаар тайлбарлав. “Аргал” гэдэг үгийг монголчуудын соёл, сэтгэлгээ түүний дотор газар зүйн онцлогоос шалтгаалсан

хэл, соёлын үндсэн нэгж биеэ даасан соёлын нэгэн цогц ойлголт болно хэмээн таамаг дэвшүүлж монгол хэлний аман болон бичгийн уран зохиолын эхийн төрөл бүрийн баримтаас түүвэрлэн авч ажиглалт хийхэд сонирхолтой дүгнэлт гаргаж болохоор байна.

Жишээлбэл, Ч. Чимэд:

*“Аргалын утаа боргилсон
Малчны гэрт төрсөн би”*

Би монгол хүн гэдгийг мэдэхгүй монгол хүн бараг үгүй. Энэ хоёр мөрөөс монголчуудын амь амьдралын гол уг үндэс болсон таван хошуу мал, аргалын утааны үнэр монгол хүний амьдрал тэр чигээрээ байгалиас эхтэй, байгалийг чин сэтгэлээсээ хайрлаж шүтэж ирсэн сэтгэлгээ илэрнэ. Харин аргал түлдэггүй өөр улс үндэстэнд малын ялгадсаас цааш үл хэтрэх хийгээд ийм мэдрэмж сэтгэгдэл төрөхөд хол байж болох юм. Ийнхүү монголчуудын таван хошуу малаа шүтэж аж төрөн амьдарч ирсэн нүүдэлчдийн өвөрмөц сэтгэлгээ орон зайн орчин, газар зүйн байрлалаас хамааран өөрчлөгдөхийг уран сайхны олон төрлийн эхэд суурилан задлан тайлбарлав.

2. Судалгааны арга зүй

Бид энэхүү судалгаандаа нийт монголчуудын аман зохиолын өв сан болон, уран сайхны эх бичвэр доторх *“Аргал”* хэмээх үг хэллэгийг дараах хам сэдвүүдийн хүрээнд түүвэрлэн авч ажиглалт хийгээд орон зайн холбогдолт баримтуудад ажиглалт судалгааг төвлөрүүлэв. Үүнд:

Б. Уртнаст (2012) *Монгол оньсого*, Г. Рэнцэнсамбуу, 3. Дашдорж (2014) *Монгол ардын зүйр цэцэн үг*, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо (2007) *Онсього*, Сувд, Төмөрцэцэг (2016) *Онсього*, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо (2016) *Монгол онсьогын тухай шилмэл* зэрэг номоос *“Аргал”* хэмээх үг орсон нийт 98 онсього, Ч. Мөнх-Уул (2007) *Зүйр цэцэн үг*, Галба, Эрдэнэчимэг (2001) *Монгол зүйр цэцэн үг ба хавт үгс*, Д. Заяабаатар, Ш. Чоймаа (2001) *Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж*, Намтайсүрэн (2009) *Зүйр цэцэн үгс*, Ф. Шуваан (2008), *Зүйр цэцэн үгийн чуулган*, Наранчимэг, Буянмандах (2021), *Алшаад уламжлагдан дэлгэрсэн ардын зүйр цэцэн үгс хийгээд онсього таавар*, Боржгин Насан – Өлзий (2015) *Морьтой холбогдсон зүйр цэцэн үг*, Мандарваа (2017) *Монгол зүйр цэцэн үгийн шилмэл*, А. Дорж (2015) *Ойрд Монголын зүйр цэцэн үгс*, И. Эрдэмт (2012) *Үзэмчин зүйр цэцэн үг онсього таавар* бүтээлүүдийн дотроос 100 гаруй зүйр цэцэн үгийг түүвэрлэн авч тэдгээрийн орон зай, газар зүйн хам орчны утгад шинжилгээ хийв.

Судалгааг хийхдээ хэл шинжлэлийн ерөнхий аргуудыг дараах байдлаар хэрэглэв. Үүнд: Баримт хэрэглэгдэхүүнийг төрөл бүрийн эх сурвалжаас түүж цуглуулаад *“Аргал”* хэмээх үг оролцсон баримтуудын утгын бүрэлдүүлбэрүүдийг

ялгаж, орон зай газар зүйн онцлог шинжийг илэрхийлсэн жишээ баримтад эх судлалын задлан шинжлэлийн аргаар ажиглалт анализ хийсэн. “Аргал” хэмээх үг нь цогц ойлголт болох талаас ажиглаж батлах зорилгоор судалгааны хэрэглэгдэхүүнд эх судлалын судалгааны аргуудыг ашиглаж ажиглалт хийв. Судалгааны өгүүлэлд ашиглах баримтыг монгол ардын аман зохиолын зүйр цэцэн үг, оньсого, хэлц үг, үлгэр, монгол ардын дууны шүлэг болон уран сайхны эхээс түүвэрлэн цуглуулав.

Эдгээрийг задлан шинжлэхдээ эх судлалын ажиглалтын ерөнхий арга, хэлний шинжилгээний утга зүйн арга, хам сэдвийн задлан шинжлэлийн арга, үгийн бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан шинжлэх аргыг ашиглаж “Аргал” хэмээх цогц ойлголт нь газар зүй, орон зайн утга илтгэж байгааг хам сэдвээс илрүүлж дүгнэлт гаргав. Мөн орон нутгийн соёлын онцлогоос шалтгаалан ялгаатай байдаг, нутаг нутгийн онцлог шинжийг агуулсан аман зохиолын зарим эх хэрэглэгдэхүүнийг хэрэглээ, хандлага, соёлын талаас ажиглаж дүгнэлт гаргах нутгийн аялгуу судлалын байдлыг тодорхойлох арга ашиглав.

3. “Аргал” хэмээх цогц ойлголтын орон зайн хүрээний ажиглалт

Аргал хэмээх үг хэллэг орсон ар, өвөр монголын хэлц, зүйр цэцэн үгсээс жишээлэн үзвэл орон нутгийн онцлогтой холбоотой ялгаатай зүйл түгээмэл байна. Тухайлбал, ар Монголын зүйр цэцэн үгнээ *“Амьд хүн аргатай, аргалын гал цогтой”*, *“Амьд хүн аргаа олдог, алтан хараацай үүрээ олдог”*, *“Нойтон аргал галын буг, нойрмог авгай гэрийн буг”*, *“Аргал түүхийн өмнө араг савраа урьтуул, ажил хийхийн өмнө арга ухаанаа урьтуул”*, *“Ах дүүгийн хол нь дээр, аргал усны ойр нь дээр”*, *“Аргалаас илч гарна ажлаас тус гарна”* зэрэг зүйр үг байхад Өвөр монголчуудын хэлэлцдэг *“Гаднаа аргалгүй, гандаа усгүй”*, *“Айлыг нь үзэхээс, аргалыг нь үз”*, *“Ажилч бүсгүй айлын чимэг, аргал түлш хотны чимэг”*, *“Аргал нь онго цонго, айл нь ундуй сундуй”*, *“Тойромдоо аргалгүй, тулгандаа галгүй”* гэх мэт зүйр цэцэн үгс байна. Эдгээр жишээ баримтад “ган, онго цонго, тойром” гэсэн үгс нь өвөр монголын орон нутгийн хэл ярианы онцлогийг хадгалсан шинжтэй юм. Эрдэмтэн Э.Равдан “Хэл – орон судлалын нэг гол судлахууныг тулгуур мэдлэг” (2005: 196) хэмээн үзсэн нь тухайн үндэстний соёлын концептын нэг бүрэлдэхүүн хэсэг болох үндэстний соёлын онцлог бүхий үг хэллэгийн тухай юм. Аргал болоод аргалын гал, аргалын утаа монголчуудын хувьд зүгээр нэг түлш түлээний тухай ойлголт бус бидний эх нутаг, байгаль дэлхий, орон нутагтаа оршин амьдрахуйн онцлогийг илэрхийлсэн угтаа нэгэн бэлгэдлийг агуулсан зүйл юм. Үүнийг олон олон жишээгээр тайлбарлаж болно. *“Тулганы гал тогтуун сайхан дүрэлзэн ноцож утаа нь бага байвал айл гэр өөдөлнө. Хэрвээ тулганы гал ноцохдоо муу, хар утаа баагиад байвал муу ёрын тэмдэг гэдэг. Хулангийн (яндангийн) утаа эгц дээшээ суунаглан мандвал өлзий бэлгэд үзэж, байн байн зүгээ буруулаад байвал хийморь хэвтэнэ.”* гэж үздэг. (Түү Буян, 2023) Монгол ардын *“Шалзат баахан шарга”* дуунд *“Аргалын хүн ажигч*

шүү, алсуур алсуур очоорой” гэсэн нь аргал түүж явахдаа амьдарч байгаа орчин тойрон, айл хунар, цаг агаар, мал сүрэг болоод аливаа хэрэг бодисыг сайтар ажиж амьдрал ахуйгаа зохицуулж явдаг шинж илэрнэ. Аргалын утаагаа шинжиж дараа өдрийнхөө уур амьсгал ямар болох, малынхаа баасыг шинжиж алдуул малынхаа босож явсан цагийг магадлах, баасных нь байдлаар өвчин эмгэгийг нь шинжих зэрэг нь нутаг нутгийн онцлогтой зүйл ч байдаг. Байгаль дэлхий, нутаг орноо бишрэн хүндлэх, дээдлэн шүтэх сэтгэлгээг аргалаар дамжуулан илэрхийлсэн нь ч байна. Жишээлбэл, “...алт аргалыг адилхан хормойлсон, арван сум Гурван гол минь...” хэмээх дуунд аргалыг ч, алтыг ч аль алиныг миний нутаг наддаа харамгүй өгдөг гэсэн эх нутгаа хайрлах сэтгэлийг илэрхийлжээ. Зохиолч Ж.Лхагвын “Аргалчин” өгүүллэгт “Өвөлжин урьшиж, хаваржин хатсан, намрын халтар аргалаар араг дөрвөлжсөө дүүргээд.” гэснийг хангайн нутгийнхан зун түүсэн аргал гэх бол говь нутгийн намар түүсэн аргал гэдэгтэй санал нэг тайлбарладаг. Энэ нь газар зүйн орчин тойрны ялгаанаас үүдэлтэй “аргал” хэмээх соёлын нэгэн цогц ойлголт хэлнээ буй болсныг тодорхой харуулах жишээ юм. Үүнийг утга зохиолд соёлын хам сэдэв ч гэж үзэх нь бий. Энэ мэт бүхий л эхэд газар зүйн орчин тойрны тодорхой хэсгийг бодит дүрслэл, өөрөөр хэлбэл хүрээлэн буй бодит ертөнц, газар дэлхийн үнэн бодит байдлын дүр зургийг үзүүлдэг бөгөөд үүний дотор тухайн орчин газар зүйн орчныг илэрхийлсэн соёлын биеэ даасан онцлог бүхий концепт үндэстний хэл бүрд байна. Үүний нэг жишээ болох “Аргал” хэмээх концептын хүрээн дэх “Аргалын гал”, “Аргалын утаа”, “Аргалын утааны үнэр”, “Тэрт оруулсан аргал”, “Гадаа овоолсон аргал” гэх үг хэллэгт нүүдэлчин монголчуудын ахуй амьдрал, газар зүйн орчны онцлог дүр зургийг харуулсан зүйл арвин байна. Л.Түдэв “Хөгнөөтэй исээ” эхэд “Монгол эртний мэргэдийн амнаас ч өрнөдийн цэцдийн бичлэгээс ч ийм санааг мэдлэгийн аргал түүхээр араг үүрч, үзгэн савар барьж явахдаа би олж мэдсэнээ исгэж, тараг бүрэхээр үүнийг бичвэй.” хэмээсэн нь эрдэм мэдлэгийг хураах урт холын аяныг “аргал түүх”-тэй адилтгадаг нүүдэлчдийн сэтгэлгээний илэрхийлэл гэж үзэж болно. Тухайн орон, газар зүйн онцлог нь тухайн үндэстний соёлын бүрдүүлбэрийг хадгалдаг төдийгүй бүтээгч гэдгийн тухай судлаачид олон зүйлээр дурдаж баталсан байдаг. “Аргал” хэмээх цогц ойлголт нь нүүдэлчин монголчууд оршин амьдарч ирсэн байгалийн орчныг тусгасан байдаг тухай эрдэмтэн Б.Пүрэв-Очир “Дошсон сарлагийн бухын дунгуй” бол сарлагтай газрын үг, хангайн үг, ер нь нутгийн аялгууны онцлогтой үг гэдгээрээ өвөрмөц юм.” (2013: 221) гэсэн байдаг. Хятадын эрдэмтэн Цан Жян Го “Хэл нь нэг зүйлийн соёлын үзэгдэл болсны хувьд түүнд орон зайн бүрэлдүүлбэр зайлшгүй нөлөөлдөг юм. Учир нь хэл хэрэглэж байгаа нийгмийн бүлэг ямар нэгэн газар зүйн орон зайн бүтцэд хязгаарлагдаж байдаг бөгөөд иймэрхүү орон зайн соёл, түүний үзэл бодлыг бүрэлдүүлж байдаг. Иймээс орон зайн соёлын тухай сэрэхүй нь тухайн үндэстний өвөрмөц онцлог бүхий үгсийн сангийн тогтолцоо, хэлний зүйн арга барил, зан заншил, цаашилбал найруулгын арга барилтай болгосноор орон зайн соёл дахь үг хэлний соёлыг бүрэлдүүлдэг байна. Орон зайн соёл нь

хэлний харилцааны арга барил, уран сайхны онцлогийг бүрэлдүүлэхээс гадна хэлний хэв маягийг төлөвшүүлдэг. Газар зүйн өөр өөр онцлог нь үзэл суртал, зан чанарын онцлог сонирхлыг төлөвшүүлэхэд тодорхой нөлөө үзүүлдэг тул газар зүйн өөр өөр орчинд өөр өөр хэлний хэв маяг бүрэлддэг. (1992: 82) гэж үзсэн байдаг. Аргалыг нэршлээр нь авч үзэхэд монгол нутгийн дөрвөн улирал ээлжлэх онцлогоос гадна хариулж байгаа малын төрөл зүйл, аргалын хөлдүү эсэх, чийг хуурайн хэмжээ, хэлбэр дүрсээр нь ялгаатай нэрлэсэн нь олон. Японы эрдэмтэн Ёши Да монголчуудын аргалын тухай нарийн тэмдэглэсэн байна. Японд зөвхөн нэг л нэртэй байхад монголчууд аргалыг нарийн төвөгтэй, олон янзаар нэрлэсэн байдаг гээд “бууц, ялгaдaс, бaас, аргал хомоол, хоргол, хөрзөн, өтөг, зунгаг, шар аргал, хар аргал, хөх аргал” (1992: 82) гэх мэт 12 зүйлийн нэр олж тэмдэглэсэн байна. Мөн эрдэмтэн Бао Хай Яен ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Баяннуур хот, Улаанцав хот, Монгол Улсын Өмнөговь аймаг зэрэг газруудаар хээрийн шинжилгээний ажил хийж, 5 хошуу малын баасны тухай “Малын баасыг ашиглах суурь болгож таван хошуу малын төрөл зүйл, улирал, таван хошуу малын нас шүд, баасных нь хөлдүү хэсэг, хуурай нойтон байдлыг үндэслэж нийт 34 нэрийдэл байна гэсэн бөгөөд хэдийгээр монголчуудын уран сайхны эхэд аргалын тухай нэрийдэл нь төдийлөн ялгаагүй боловч бодит амьдралд газар орныхоо онцлог ба хариулж байгаа малаасаа шалтгаалж аргалын нэрийдэл их зөрүү гардаг. Ийм нөхцөлд алиныг зөв хэмээн үзэж үндсэн нэршил болгоход хэцүү болдог” (2022: 74) гэжээ. Үүнчлэн таван хошуу малын баасны нэршил газар орны онцлог, хариулж буй мал сүргийн байдал, үндэстний сүсэг бишрэл, зан үйл зэргээс шалтгаалж ялгаатай байдаг. Эрдэмтэн судлаачдын судалснаар Хөх нуурт Төвөдийн өндөрлөгт аргалын нэрийдэл нийт 56 байна. Монголын өндөрлөгт аргалын нэрийдэл нийт 35 бий. Хөх нуур Төвөдийн өндөрлөгт аргалын тухай нэрийдэл нь ихэнхдээ үйлдвэрлэж гаргасан бүтээгдэхүүнийх нэршил байдаг бол Монгол Улсад иймэрхүү боловсруулж гаргасан бүтээгдэхүүнээр нэрлэсэн нь цөөн. Харин хариулж байгаа мал нь үхэр үү, сарлаг уу гэдгээс шалтгаалсан нь элбэг. Сарлагийн баас нь хатаахад хэцүү, бас амархан бяцардаг, иймээс заавал боловсруулах хэрэгтэй. Монголчууд аргалыг өнгөөр нь ялган дүрсэлж нэрлэдэг нь өнгийг чухалчлан эрхэмлэдэгтэй холбоотой болов уу. (Бао Хай Яен, 2022: 179)

Алшаа монголчуудыг авч үзвэл, газар зүйн байц нь элс манхан, говь цөл, шил адаргаар голлож хур бороо цөөнтэй, салхи шуурга ихтэй зэрэг уур амьсгалын онцлогоос болж таван хошуу малын дотроос голдуу тэмээ, хонь, ямаа хариулдаг. Тэмээнийхээ хорголыг аргал түлш болгон хэрэглэх бөгөөд “аргас, хоргос” гэж нэрлэдэг. Эрдэмтэн Бао хай яен “Тува үндэстэн аргалыг арсан гэж нэрлэдэг. Аргасан гэдэг нь аргалын эртний хэл, энэ нь Хөх нуурын монголчуудын аргалын нэрийдэлтэй адил” (2022: 90) гэснээс үзэхэд алшаачуудын “аргас хоргос” гэдэг нь үүнтэй холбоотой бололтой. Учир нь алшаа монголчууд бол Шинжаанаас Хөхнуур, Ганьсугаар дамжин ирж нутагласан байдаг. Үүний тухай эрдэмтэн Дорг. Боржигид. Оч Алшаа хошууд зан үйл номд “17 дугаар зууны далаад оны үед Очирт цэцэн хааныг дагаж байсан Гүш Хааны хөвүүн Баян авхай Аюуш олон

хөвүүдийн хамт Хөх нуур зүг зайлан одсон билээ. Энэ үед Баян авхай Аюушийн 4 дүгээр хөвүүн баатар эрх жонон Хорлой мянга гаруй өрх 7 мянга гаруй албатаа дагуулж Хөх нуураар дамжин баруун Туулын Алишаад Ирсэн тухай ‘Алишаагийн шар дансанд’ тодорхой тэмдэглэл байдаг” (2018: 14-15) гэж бичсэн байна. Алшаачуудын дунд “аргас хоргос” гэх үгээс гадна “хайс (тогоо), үрүүн (өглөө), асган (үдэш)” гэх мэт нутгийн аялгууны үг хэллэг олон бий. Алшаад үхэр цөөн байдаг учир голдуу тэмээнийхээ хорголыг заг, хожуул, можгоо мэтийн түлээтэй хольж түлдэг. Аргалын утаа нь алшаачуудын сэтгэлд буухад тэмээний хорголын дүрэлзэн ноцож байгаа дүр зураг буух нь дамжиггүй. Тэмээний хорголын гал илчтэй боловч асахдаа муу, нэг асчихвал сайн шатах бөгөөд хатааж хадгалахад сайн, үнс утаа багатай байдгаараа Алшаа монголчуудын сайн түлшний нэг болсоор ирсэн юм. Аргал түүх-ийн тухайд алшаачууд араг шээзгий үүрээд аргал түүх биш гараараа буюу жижиг савраар тэмээний хорголоо хамж түүгээд уут буюу сумалд хийдэг. Тэмээний хорголоо хадгалах ба хураах талаар ч гэсэн орон нутгийн өвөрмөц онцлог бий.

Монгол хэлнээ газар зүйн орчин тойрны бодит байдлын дүр дүрслэл, хүрээлэн буй бодит ертөнц, газар дэлхийн онцлог байдлыг үгийн сангийн хам сэдвээс тодруулж үзвэл сонирхолтой олон янзын тайлбар гарах боломжтой байна. Төрөл бүрийн уран сайхны эх тухайлбал, дуу шүлэг, зүйр цэцэн үг, хэлц гэх мэтэд газар зүй, тухайн орон нутгийн соёлын онцлог тусгалаа олсон нь арвин. Зүйр цэцэн үг нь хүн төрөлхтний бүтээсэн соёлын нэгэн илэрхийлэл, соёлын бүтээгдэхүүн, соёлын нэгэн хэлбэр юм. Хэл, соёлын харилцан нөлөөллийг газар зүйн орчин, орон зайн шинжээс илрүүлж харвал, тухайн ард түмний хэл нь соёлоо бүрдүүлэхэд онцгой чухал нөлөө үзүүлдэг тухай эрдэмтэд олон зүйлээр тайлбарласан нь бий. Энэ тухай БНХАУ-ын эрдэмтэн Цан Жян Го Газар зүйн орчин тойрон нь уугуул нутгийн ард түмний зан заншил, өвөрмөц дүр төрх, гоо зүйн таашаал сонирхлыг тусгадаг. Энэ үүднээс авч үзвэл орон зайнаас үүдэж хэл ярианд гарсан хувирал нь хэлний зөвхөн хэлний болоод газар зүйн үзэгдэл биш соёлын үзэгдэл юм. Тухайн орон нутгийн зан заншил, дадал зуршилтай уялдан соёлын нэгдэл бүрэлддэг. Хэл бол орон зайн цогц ойлголт, орон зайн хэллэг бол хэл юм. (Цан Жян Го, 1992: 71) гэжээ. Мөн Японы эрдэмтэн Хоуго Синшан “Хэл, утга зохиол, урлаг нь ардын зан заншилд хамаарна. Энэ нь голдуу нутгийн дуу шүлэг, зүйр цэцэн үгс, хэлц зэрэгт газар зүйн болон орон нутгийн соёлын өнгө төрх тусгалаа олсон байдаг” (1984: 64) гэж үзсэн байна. Ард түмэн бүр оюун санааны соёлын амьдралын явцад зүйр цэцэн үгс зэрэг хэлний баялаг санг бүтээж ирсэн байна.

4. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

“Аргал” хэмээх хэл, соёлын цогц ойлголт газар зүй, орон зайнаас хамаарах нь

Уран сайхны эх бичвэр хийгээд харилцааны өгүүлэмжийн олон янзын хам

орчинд байгаль дэлхий, хүний амьдралын элдэв хэрэг явдлыг өгүүлэхдээ тухайн соёл, хэлт үндэстэн өөр өөрийн онцлог шинжийг тусган харилцах өнгө өнгийн арга ухаантай гэдгээ хэлний олон арга хэрэглүүрээр илэрхийлсэн байдаг. Энэ талаар хэл шинжлэлч Б.Пүрэв-Очир (2007) “Дэлхийн олон хэлтэн өвөр зуураа харилцан нэвтрэлцэж, төгс өгүүлбэр, цогцолбор, мөчлөг, эхийг бүтээхдээ хэрэглэдэг *ам нээх авиа* болон *уушиг нээх үг* нь онд ондоо байдаг бололтой. Тухайлбал: Орос хэлэнд “*ну*”, “*это самое*”, гэх зэрэг сул үг, аялга үгийг гол төлөв хэрэглэж, ярианы эхлэлийг тавьдаг байхад, англи хэлэнд “*well*” гэсэн сул бүрэлдэхүүн, өгүүлэгч ба сонсогчийг холбоонд оруулах үгийг олонт хэрэглэж, “*ам нээдэг*” байна. Монгол хүн “*За*”-аар *ам нээн хэлэлцэж, ярианы эхлэлийг уужуу талбиун тавиад, өвөр зуураа хэлэлцсэн сэдэв, яриа, утга санааг зөвшилцөн баталж зөвшөөрөхдөө мөнхүү “За-аар ам хаадаг” ёс журамтай нь сэтгэгц хэл шинжлэлийн нарийн учир холбогдолтой сонин содон зүй тогтол болой.* (Пүрэв-Очир, 2007: 228) гэсэн байдаг. Аливаа ард түмний соёл, сэтгэлгээ хэлний ялгаанаас шалтгаалан өөр өөр байдаг шиг үндэстэн дотроо орон нутаг, газар зүйн онцлогоосоо болж өөр өөр соёлыг бүрдүүлсэн нь хэлээр илрэх соёлын цогц ойлголтод тод тусгалаа олсон байна. Ерөөс тухайн хэлнээ туссан аливаа дүр зураг тухайн үндэстний оюун сэтгэхүйд туссан ертөнцийн дүр зураг болдог байна. Аль ч үндэстний ертөнцийн тухай ерөнхий суурь ойлголтод жилийн дөрвөн улирлын шинж байдал байдаг боловч үндэстэн бүр цаг улирлын өнгө төрхийг хэрхэн яаж үздэг ялгаа нь хэл хэлнээ илэрсэн байдаг. Е.М.Верещагин, Н.М.Костомаров нар дэвсвэр (суурь) мэдлэг (фоновое знание) - ийг дараах хэд хэдэн бүлэгт хуваасан байна. (Верещагин, Е. М., Костомаров, Н. М., 1976)

Үүнд:

- Хүн төрөлхтний ерөнхий суурь ойлголт: орчилт цаг (өвөл, намар, зун, өдөр, орой, шөнө, нар, од), газар зүйн мэдлэг, хүний тухай, сансар огторгуйн тухай, библийн дүр дүрслэл, домог үлгэр, шинжлэх ухааны мэдээлэл гэх мэт
- Тив улсын суурь ойлголт: Бүх хүн цас, элсэн цөл, хар салхи, цагаан шөнө, хойд туйлын туяа гэх мэтийг мэддэггүй
- Орон судлалын суурь ойлголт: Тухайн угсаатан хэлний бүлэг л мэдэх ойлголт
- Нийгмийн болон мэргэжлийн хүрээнийхний суурь ойлголт: эмч, багш, нэг хот суурины иргэд гэх мэт явцуу хүрээнийхний ойлголт орно. (Папина, 2002: 335)

гэснээс үзвэл мэдээллийг дамжуулж буй хэлний тэмдэг нь аливаа зүйлийг нэрлэх утгатай байхаас гадна харилцагч хүмүүсийн хувийн намтар, амьдралын туршлага, үндэсний ахуй соёл, эргэн тойрны хүмүүсийн соёлын тухай нэмэлт мэдээллийг агуулдаг байна. Үүнийг О.С.Ахманова “Суурь мэдлэг нь харилцагч хоёр хүний харилцааны үндэс болох бодит амьдралын тухай мэдээллийг агуулдаг” (1957: 109) гэсэн нь ч чухамдаа аливаа мэдээлэл өрнөх, ойлголцох

суурь нь тухайн хэлэлцэгч хүмүүсийн соёлын концепт болохыг хэлжээ. В.Солоухин “Хэрэв чи орос хүн мөн бол Пушкин гэж хэн болох, Куликовын тал гэж юу болох, Третьяковын галлерей, гуравласан морийг мэддэг байх ёстой.” (1969: 7) гэснийг үндэстний суурь мэдлэгт хамааруулж үзэж болох юм. Аливаа эхийн мэдээлэл бүрэлдэх суурь нь тухайн цаг хугацаа, газар орон, үйл явдал тухайн зохиолчийн нийгэмд эзлэх байр суурь, тухайн үеийн сэтгэл зүйн байдал, эх бичихэд хүргэсэн шалтгаан, онгод зэрэг маш олон зүйлийн хам сэдвээс шалтгаална. Тухайлбал, алив үндэстэн байгалийг ямар нэгэн зүйлтэй адилтган дүрслэх нь түгээмэл байдаг. Энэхүү адилтгал нь бэлгэдлээр дамжин илэрдэг. Бэлгэдэл нь үндэстний сэтгэлгээний онцлогийг илрүүлэх хамгийн чухал хэрэглүүр болно. Энэ тухай Н.Д.Арутюнова “Орос улсын бэлгэ тэмдэг нь хязгааргүй замууд, аль эсвэл гуравласан морь, гурван хус мод, эсвэл хязгааргүй тал, Кремлийн Спасс цамхаг, аль эсвэл Василий Блаженный сүм” (1999: 340) гэсэн бол *Аливаа улс үндэстний яруу найргийн сэтгэлгээний өвөрмөц чанарыг илэрхийлэх шинж буй. Тэр нь тухайн орны байгалийн онцлогтой холбоотой. Эгц өндөр хадан байцас, омогт хүрэн бүргэд, их цасан нурлага, уулын голын шуугиант ширүүн урсгал зэрэг нь Кавказын яруу найргийн өнгө төрхийг илэрхийлдэг бол, дорнын цагаан сар, тэнгис далайн хярхаг дээгүүр хөвж яваа улаан нар, тэргүүлэгч цэцгийн цагаан түрүү, хулсан лимбэний исгэрэх аялгуу зэрэг нь Хятадын яруу найргийн шинж болоод гоолиг цагаан хус мод Оросын яруу найргийн бэлгэ тэмдэг байх жишээтэй. Тэгвэл монгол яруу найргийн онцлог дүр төрх нь юу вэ? гэсэн асуулт гарна. Юуны өмнө монгол яруу найргийн онцлог төрх нь эргэх дөрвөн цагтайд буй. (Г.Мэнд-Ооёо, 2007: 29-30) гэжээ. Ийнхүү аль нэг үндэстний соёл сэтгэлгээний онцлог өөрсдийнх нь ухамсарт үлдэж хоцордог бөгөөд тэдгээр нь аман ба бичгийн харилцаагаар илэрч байдаг. Энэхүү утга үндэстний соёлын үзэгдэл тул тухайн хэл соёлын мэдээллийг тээгч үнэт зүйлийн нэг хэсэг болох нь дамжиггүй юм. Тиймээс хэл бол хүний танин мэдэхүйг бүрэлдүүлэгч, соёлыг тээгч юм. Н. Нансалмаа “Хүний амьдрал бүхлээрээ танин мэдэх үйл. Төрснөөс үхэх хүртэл танин мэдэх үйл үргэлжилнэ. Хүүхэд хэлд орох үйл зүгээр нэг үг тогтоогоод байгаа хэрэг биш. Тэр хэлээр дамжуулж амьдарч буй орчноо танина.” (2019: 98) гэснээр хүний төрөх, хэл орохоос аваад үхэн үхтэл салшгүй нэгэн зүйл бол төрсөн хийгээд амьдарч буй, амьдарч байсан газар орон юм. Энэ нь тухайн хэлний үг бүрд бус тухайн үндэстний соёлын цогц ойлголтыг хадгалж буй үг хэллэгт л хадгалагддаг байна.*

5. Дүгнэлт

Монгол хэлний “Аргал” хэмээх цогц ойлголтыг соёл, хэл шинжлэлийн үндсэн ойлгогдохууны нэг болох газар зүй, орон зайн шинжээс хамааран утга илтгэх талаас ажиглалт хийхэд:

1. Үг хэл нь цаг хугацааны соёлыг илэрхийлээд зогсохгүй орон зайн утгаас ангид зүйл биш юм. Газар зүйн орчин, орон зай нь үг хэлний онцлог буй

болоход чухал нөлөө үзүүлдэг. Тухайн үндэстний үг хэллэг соёл оршин суугаа газар орны байдлаас шалтгаалан өөр өөр хам сэдвийн утгыг бүрэлдүүлж байна. Энэ нь тухайн үндэстэн ястны сэтгэлгээний онцлог хэлнээ тусахдаа оршин буй оронтой хамаарал бүхийг илтгэж байна.

2. Тухайн хэлний дүрслэл нь газар зүйн орчин тойрон, цаг хугацаа, орон зайн хүрээний соёл, зан заншлын нэгэн зүйл бүтэц хэмээн үзэж болно.
3. “Аргал” хэмээх цогц ойлголт нь тухайн улс үндэстнийхээ оршин амьдарч байгаа газар зүйн орчин тойрноос шалтгаалж өвөрмөц орон зайн хүрээний соёлыг бүрэлдүүлдэг.
4. “Аргал” хэмээх цогц ойлголтын хүрээнд монголчууд олон зүйлийн соёлын хүрээг бүрэлдүүлжээ. Оршин амьдарч байгаа байгалийн салхийг дуу аялгуутайгаа зүйрлэн орчин тойрныг зураглахдаа, монгол нутгийн өвөрмөц газар зүйн орчныг үзүүлж, монгол гэрийнхээ тооноор дээд тэнгэрээ хардаг, гал голомт, тэнгэр бурхнаа шүтдэг, түүнээсээ сэтгэлийн дотоод хүчийг олж амьдралдаа итгэл дүүрэн явдаг зан чанарын онцлогтой хамт “Аргалын утааны үнэр” эх орныг нь төлөөлдөг монгол үндэстний орон зайн илэрхийллийн нэгэн онцлог юм.
5. Монголчуудын хэл соёлын үндсэн нэгж, соёлын биеэ даасан цогц ойлголт “Аргал” хэмээх үг хэллэгээр илэрч болно. “Аргал” хэмээх цогц ойлголт нь монголчуудын оршин амьдрах газар зүйн орчин тойронтой нягт холбогдож тэр үндэстнийхээ өвөрмөц сэтгэхүй, зан заншил, үг хэлний онцлогийг бий болгосон байна гэж үзэж болохоор байна.

Талархал

Энэхүү өгүүллийг удаа дараа нягтлан уншиж, хянан магадалсны тус дэмд зохиогч бид засан сайжруулснаар тус сэтгүүлд хэвлэж нийтийн хүртээл болгох боломж олгосон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын “Хэрэглээний хэл шинжлэл” сэтгүүлийн зөвлөлд талархаж буйгаа илэрхийлье.

Ном зүй

- Дорг, Боржигид, Оч. (2018). *Алшаа хошууд зан үйл*. Хөх хот: Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн газар. [Dorg, Borjigid, Och. *Alshaa khoshuud zan uil* [Alsha Khoshuud Rituals]. Hohhot: Inner Mongolia Publishing Group, Inner Mongolia Science and Technology Professional Publishing House. 2018.]
- Мэнд-Ооёо, Г. (2007). *Яруу найраг шидэт долгион 1*. Улаанбаатар. [Mend-Ooyo, G. *Yaruu nairag shidet dolgion 1* [Poetry: The Magical Waves 1]. Ulaanbaatar. 2007.]
- Нансалмаа, Н. (2019). *Нийгэм хэл шинжлэл*. Улаанбаатар: МУИС Пресс. [Nansalma, N. *Niigem khel shinjlel* [Sociolinguistics]. Ulaanbaatar: National University of Mongolia

- Press. 2019.]
- Пүрэв-Очир, Б.** (2007). *Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ*. Улаанбаатар. [Purev-Ochir, B. *Mongol khelnii butets, utga, uureg, khereglee* [Structure, Meaning, Function, and Usage of the Mongolian Language]. Ulaanbaatar. 2007.]
- Пүрэв-Очир, Б.** (2013). *Судалбар эсээнүүд*. Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК. [Purev-Ochir, B. *Sudalbar eseeenuud* [Research Essays]. Ulaanbaatar: Munkhiin Useg LLC. 2013.]
- Равдан, Э.** (2005). *Орчин цагийн хэл шинжлэл*. Улаанбаатар: МУИС Пресс. [Ravdan, E. *Orchin tsagiin khel shinjlel* [Modern Linguistics]. Ulaanbaatar: National University of Mongolia Press. 2005.]
- Ахманова, О. С.** (1957). *Очерки по общей и русской лексикологии*. Москва: Государственное учебно-педагогическое издательство Министерства просвещения РСФСР. [Akhmanova, O. S. *Ocherki po obshchey i russkoy leksikologii* [Essays on General and Russian Lexicology]. Moscow: State Educational and Pedagogical Publishing House of the Ministry of Education of the RSFSR. 1957.]
- Арутюнова, Р. Д.** (1999). *Язык и мир человека*. Москва: Языки русской культуры. [Arutyunova, R. D. *Yazyk i mir cheloveka* [Language and the World of Man]. Moscow: Languages of Russian Culture. 1999.]
- Боо Хай, Яен.** (2022). *Хятадын дотоод хуурайгийн аргал уламжлалт аж ахуйн судалгаа*. Бээжин: Ардын хэвлэлийн газар. [Boo Hai, Yaen. *Khyatadiin dotood khuuraigiin argal ulamjalt aj akhuin sudalгаа* [Study of the Traditional Economy of the Dry Dungs of China]. Beijing: National Publishing House. 2022.]
- Верещагин, Е. М., Костомаров, Н. М.** (1976). *Язык и культура*. Москва. [Vereshchagin, E. M., & Kostomarov, N. M. *Yazyk i kultura* [Language and Culture]. Moscow. 1976.]
- Ёши Да.** (1982). *Монгол түлш аргал хоргол*. Бээжин. [Yoshi Da. *Mongol tulsh argal khorgol* [Mongolian Fuel: Argals and Khorgols]. Beijing. 1982.]
- Папина, А. Ф.** (2002). *Текст: Его единицы и глобальные категории. Глава IV. Типы информации текста (высказываний, ССЦ)*. Москва. [Papina, A. F. *Tekst: Ego yedenitsy i globalnye kategorii. Glava IV: Tipy informatsii teksta (vyskazyvaniy, SCC)* [Text: Its Units and Global Categories. Chapter IV: Types of Information in Text (Statements, SCC)]. Moscow. 2002.]
- Солоухин, В.** (1972). *Черные доски*. Москва: Советская Россия. [Soloukhin, V. *Chyornye doski* [Black Boards]. Moscow: Soviet Russia. 1972.]
- Түү Буян.** (2023). *Аргалын соёл. Хөх хот: Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн газар*. [Tuu Buyan. *Argaliin soyol* [Culture of Dung]. Hohhot: Inner Mongolia Science and Technology Professional Publishing House. 2023.]
- Хоүто Синшан.** (1984). *Зан үйлийн ухаан. Орчуулгын дэвтэр*. [Khouto Sinshan. *Zan uiliin ukhaan. Orchulgiin devter* [Ritual Science. Translation Book], 1984.]
- Цан Жян Го.** (1992). *Соёл хэл шинжлэл*. Леонгийн сурган хүмүүжлийн хэвлэлийн газар. [Tsang Jiang Guo. *Soyol khel shinjlel* [Cultural Linguistics]. Leon: Leon Educational Publishing House. 1992.]

ХАВСРАЛТ

Ажиглалт судалгаанд ашигласан “Аргал, хоргол” гэсэн үг оролцсон зүйр үгсийн жишээ:

1. Амьд хүн аргатай
Аргалын гал цогтой
2. Амьд хүн аргаа олдог
Алтан хараацай үүрээ засдаг
3. Айсан хүнд аргал хөдөлнө.
4. Нойтон аргал галын буг
Нойрмог авгай гэрийн буг
5. Аргал түүхийн өмнө араг савраа урьтуул
Ажил хийхийн өмнө арга ухаанаа урьтуул
6. Ах дүүгийн хол нь дээр
Аргал усны ойр нь дээр
7. Аргалаас илч гарна
Ажлаас тос гарна
8. Залхуугийн гадна түлшгүй
Залгидгийн гэрт хоолгүй
9. Сэтгэлд гал байхад тулганд хомоол олдоно.
10. Галдаа аргалгүй
Гандаа усгүй
11. Айлыг нь үзэхээр
Аргалыг нь үз
12. Ажилч бүсгүй айлын чимэг
Аргал түлш хотны чимэг
13. Аргал нь онго цонго
Айл нь ундуй сундуй
14. Тойромдоо аргалгүй
Тулгандаа галгүй
15. Алд дэлмийн хэмжээг мэдэхгүй
Аргал хорголын ялгааг мэдэхгүй
16. Алт өвөрлөсөн хүн хөлдөж үхнэ
Аргал өвөрлөсөн хүн хөлдөж үхэхгүй
17. Алт түлбэл өнгө гарна
Аргал түлбэл үнс гарна
18. Анхны шуурганд малаа алдвал аавын муугийн харгай
Аргал үгүйдэж гал алдвал охины нь муугийн харгай
19. Арьс ноос байман баян

- Аргал түлш байман дулаан
20. Эх хөгширвөл эмгэг
Аргал шатвал үнс
21. Айл хэсэхээр адуундаа яв
Алжуурч суухаар аргалаа түү
22. Алд дэлмийн хэмжээг мэдэхгүй
Аргал хөлдүүсийн ялгааг мэдэхгүй
23. Алтыг аргал гэх
Аргалыг алт гэх
24. Алтны өнгө хэзээд шар
Аргалын үнс хэзээд буурал
25. Адуутай хүн онош дутахгүй
Аргалтай хүн түлш дутахгүй
26. Аргалын үнэр галдаа
Арцны үнэр утаандаа
27. Хоньтой хүн хоолтой
Хорголтой айл илчтэй
28. Хоргол дээр гарсан шоргоолж
Хурмастад гарчихлаа гэх
29. Илжигний чихэнд алт хийвч сэгсэрч
Аргал хийвч сэгсрэх
30. Аргалын гал үнс ихтэй
Алжуу хүн нойр ихтэй
31. Айл хэсэхээр адуундаа яв
Алхайж хэвтэхээр аргалдаа яв
32. Хов зөөсөн хүний ам завгүй
Хомоол зөөсөн хүний гар завгүй
33. Айл тойрохоор адуундаа яв
Алжуурч суухаар аргалаа түү
34. Аавын хүүг архи барна
Аргал түлээг гал барна
35. Аав хүнд цээрлэл арвин
Аргал түлээнд үнс арвин
36. Аавын муу нь авга
Аргалын муу нь ширтэс
37. Ууланд яваад аргалгүй
Эргэж ирээд аргалгүй
38. Алтыг аргалаар зарах
39. Ах дүүгийн хол нь сайн

- Аргал усны ойр нь сайн
40. Алтыг аргалаар үзэж
Амьдралыг тоглоомоор үзэх
 41. Аргалын гал утаатай
Амьд амьтан аргатай
 42. Аргалын гал үнс ихтэй
Ардаг зан саад ихтэй
 43. Хоньтой айл хоолтой
Хорголтой айл илчтэй
 44. Айхад аргал хөдөлнө
Бачимдахад бараа хөдөлнө
 45. Адуутай айл баян
Аргалтай айл дулаан
 46. Аргалын овоо бүдүүнээр ажилсагийг мэднэ
Адуун сүрэг зузаанаар баяныг мэднэ
 47. Аргалын галын үнс арвин
Алжуу морины баас арвин
 48. Аргас хөдөлгөдөг өд шиг
Ааваас өөр хүн танихгүй
 49. Аргасын галаас илч гарна
Ажил хөдөлмөрөөс тос гарна
 50. Хов зөөсөн хүний ам завгүй
Хоргос түлсэн хүний гар завгүй
 51. Ховч хүний ам завгүй
Хомог түлсэн хүний гар завгүй
 52. Хоньчны үүдэн дээр
Хоргос худалдах
 53. Алтыг аргасаар үзэх
Аргасыг алтаар үзэх
 54. Хумхиа цэвэрлэсэн эрүүл болно
Хоргосоо дуулгаад баян болно
 55. Аргаар цуглуулсан өв хөрөнгийг
Аргал болгон шатааж болохгүй
 56. Амьд хүн аргатай
Аргалын гал гэгээтэй
 57. Арга байвал зараад барахгүй
Аргал байвал түлээд барахгүй
 58. Аргалаа барсан айл галгүй
Алдраа гэсэн хүн хүндгүй

59. Хонь шиг номхон
Хоргол шиг бөмбөргөн
60. Хоосон газраас хог шүүрдмээр
Хорголон бааснаас хатгаж авмаар
61. Хомоол адил хөвсгөр
Хожил адил үрчгэр
62. Авдар хийх гэсэн нь араг болох
63. Арав ирвэл аргал
Хорь ирвэл хоргол
64. Арга ухаангүй анчин
Аргалын овоо үзэхгүй
65. Аргал түүхэд савар хэрэгтэй
Ажил хийхэд арга хэрэгтэй
66. Аргал түүхэд савар хэрэгтэй
Ажил хийхэд багаж хэрэгтэй
67. Аргал түлээний хог
Аяга цайны шаар
68. Аргалаас илч гарна
Арцнаас үнэр гарна
69. Аргалын гал үнс ихтэй
Алжуу хүн нойр ихтэй
70. Аргалын тус илч
Ажлын тус тос
71. Аргалын тусаар гэр дулаацах
Ажлын тусаар амьдрал дулаацах
72. Хоноцын хүнд аргал бүү бариул



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.